



МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ
НОМЫН САН

THE NATIONAL LIBRARY OF MONGOLIA

Мэдээлэл арга зүй,
эрдэм шинжилгээний хэлтэс

ШИНЭ НОМЫН МЭДЭЭ

/Сар тутмын товхимол/

2020 №2



УЛААНБААТАР ХОТ
2020 он

Байгалийн шинжлэх ухаан



1. Золбаяр Ж. (Амай)

Монгол бадарчин / Хян. Ц.Жамбалсүрэн, М.Алтанцэцэг ба бус.; Зөвл. Т.Дорж, Л.Хайсандай.- УБ.: Тайвшир хэвл.

Б.2: Амьдрал сайхан шүү, 2018.- 400х.- ISBN 978-99962-1-244-4.

26.89

3-646

2-94741 - 2-94745

Жамбалсүрэнгийн Золбаяр буюу Амай-н “Амьдрал сайхан шүү” ном та бүхний гар дээр очиж байна. Юм үзэж, нүд тайлна гэдэгт хүнийг хүн болгохын нэгэн шидэт түлхүүр оршино. Дэлхийг тойрсон гэгддэг Магелланаас илүү замыг бэдрэн туулж, ёстой бадарчин маягаар дэлхийтэй танилцаж, ертөнцийн олон ард түмний зан заншил, амьдралыг зураг, тайлбарын хамт дэлгэрэнгүй бичжээ.

2. Золбаяр Ж. (Амай)

Монгол бадарчин / Ред. Ц.Жамбалсүрэн, Ч.Авдай; Зөвл. Т.Дорж, Л.Хайсандай.- УБ.: Тайвшир хэвл.


Б.5: Цаг хугацаагаар, 2018.- 400х.: Зур.- ISBN 978-99978-1-554-5.

26.89

3-646

2-94746 - 2-94750

Дэлхий ертөнцийн өнцөг булан бүрд Монгол хүний мөр гаргаж, Тусгаар улсынхаа далбааг мандуулж байгаль дэлхий, хүн төрөлхтөн, соёл иргэншлийн тухай бодит мэдээллийг Монгол хэлээрээ угсаа нэгтнүүддээ хүргэх дараагийн үеийнхэндээ зориулав.



3. Золбаяр Ж. (Амай)

Монгол бадарчин / Ред. Ц.Жамбалсүрэн, Ө.Оюун; Зөвл. Т.Дорж, Л.Хайсандай.- УБ.: Тайвшир хэвл.

Б.6: Амьдрал бол аялал, 2019.- 400х.: Зур.- ISBN 978-9919-21-445-6.

26.89

3-646

2-94751 - 2-94755



Монгол бадарчин Ж.Золбаярын “Амьдрал бол Аялал” номтой хамт дэлхийгээр аялахад бэлэн үү? Монгол Бадарчин төслийн зургаа дахь боть болох уг номын гол зорилго бол уншиж буй хүний оюун санааг өдөр тутмын давтамжаас амрааж, цаг хугацаа, орон зай, өөр өөр соёл иргэншил, сонирхолтой амьдралаар аялуулахад оршиж байна. Нийт 14 жилийн

хугацаанд, 200 гаруй гэр бүл, 1000 гаруй хүн ажиллаж, 86 улсыг судалсан асар их хөдөлмөрийн үрээр энэхүү бүтээл мэндэлсэн байна.



4. Мөнх-Очир Д.

Сонины өгүүлэл, нийтлэл, ярилцлагын эмхэтгэл.- УБ.: Арвай бархан, 2019.- 302х.- ISBN 978-99978-724-5-6.

22.6

М 816

3-18580 - 3-18582

5. Шаандар П., Өлзий-Орших Ш.

Метал бус ашигт малтмалын ордын эрлийн цогцолбор арга / Ред. Ж.Лхамсүрэн, П.Дугармаа.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 536х.- ISBN 978-99978-3-924-4.

26.342

Ш 106

3-18533 - 3-18535



Уг бүтээл нь метал бус ашигт малтмалын тухай ерөнхий ойлголт, түүний онцлог, геологийн гарал үүсэл, тархалтын зүй тогтол, ангилал, олборлох, боловсруулах арга зам хийгээд Монгол Улсын метал бус ашигт малтмалын геологийн судалгааны хөгжлийн талаар товч өгүүлсэн болно. Ашигт малтмалын төрөл болгоныг бие даасан бүлэг болгосноос гадна бүлэг тус бүрт тухайн ашигт малтмалын тухай ерөнхий ойлголт, түүний хэрэглээ, чанарт тавих шаардлага, үйлдвэрлэлийн ордын гарал үүслийн төрөл, дэлхийн сонгодог ордуудын жишээ, түүнчлэн Монгол Улсад судлагдсан байдал, төлөөлөх ордуудын товч бичиглэлийг оруулсан байна.

Техник. Техникийн шинжлэх ухаан



6. Дизайн: Их, дээд сургуулийн суралцагчдад зориулсан сурах бичиг / Ред. Р.Гоцбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 284х.: Зур.- (МУБИС).- ISBN 978-9919-9563-5-6.

30.18

Д 412

3-18591 - 3-18594

Эрүүлийг хамгаалах. Анагаахын шинжлэх ухаан



7. Монгол эмийн судлал / Эрхэл. Баян; Хөрв. Г.Гомбожамц; Хян. Х.Туул.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 480х.: Зур.- ISBN 978-99978-4-397-5.

52.81

М 692

3-18543 - 3-18545

Сүүлийн үед дэлхий нийтээрээ уламжлалт анагаах ухаан түүний дотроос байгалийн гаралтай эмт бодис, ургамал, амьтан, эрдсийн гаралтай эмийг хэрэглэх явдал нэмэгдэж байна. Тус бүтээлд монгол эмийг түүх, хадгалах, байгалийн гаралтай уламжлалт эм бэлдмэлийн зөв зохистой хэрэглээг хангахад эм зүйн ерөнхий мэдлэг, монгол эмийн ангилал, эмт бодисыг номхотгох, хэрэглэх арга зэргийг багтаажээ. Мөн эмийн зүйлийн англи, орос нэр орчин үеийн судалгаа зэргийг нэмж оруулсан байна.

Түүх. Түүхийн шинжлэх ухаан


8. Монголын археологи-2019: Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл / Эрхэл. Ч.Амартүвшин, Ж.Баярсайхан.- УБ.: [Хэвлэлийн газаргүй], 2019.- 448х.: Зур.- (ШУАТАХ. Монголын Үндэсний музей. МУИС.).

63.4(5Мон)

М 695

3-18506 - 3-18510

Архангай аймгийн Өлзийт сумаас урагш Монгол орны хэвтээ тэнхлэгийн мянганы замтай холбосон 30км авто замын трасст явуулсан археологийн авран хамгаалах малтлага, Архангай аймгийн Хотонт сумын өвөр хавцалын амны IV дөрвөлжингийн 2019 оны малтлага, Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын нутаг нүхэн хаданд хийсэн археологийн судалгаа нийтлэгджээ.



9. Монголын археологийн шинэ судалгаа / Ред. Н.Батболд, Ж. Гантулга, Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Магай.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 191х.: Зур.- (ШУАТАХ.)- ISBN 978-99978-972-1-3.

Б.4: Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судалгаа: Хойд тамирын хөндий дэх археологийн судалгаа-2.

63.4(5Мон)

М 695

3-18511 - 3-18515

Хөрөөгийн үзүүрийн хадны зургийн судлагдсан байдал, тархалт, байршил, хадны зургийн ангилал, дүрслэлийн арга, онцлогыг тусгажээ.



10. Мөнх-Очир Д.

Монгол улсын аймаг, хошуу сум, шавь, отог хошууны ноёд.- УБ.: Арвай бархан, 2019.- 162х.- ISBN 978-99978-724-7-0.

63.5(5Мон)

М 816

3-18583 - 3-18585

Энэхүү номын агуулгад: Нэгдүгээр бүлэг: Манжийн үеийн ба олноо өргөгдсөн Монгол Улсын аймаг хошуу, Хоёрдугаар бүлэг: Дэлгэр Их уулын аймгийг байгуулсан нь, Гуравдугаар бүлэг: Аймаг, сумыг дахин шинэчлэн зохион байгуулсан нь, Дөрөвдүгээр бүлэг: Өнөөгийн Монгол улсын аймаг, сум, Тавдугаар бүлэг: Монгол Улсын хошуудын засаг ноёд, Хавсралт бүлэг: Монгол улсад дагаар орсон буриадууд гэсэн сэдвүүд орсон байна.

11. Мөнх-Очир Д.

Чандмань уулын аймгийн наран хайрхан уулын хошууныхан: Ховд аймгийн Буянт, Дуут, Мөнххайрхан, Ховд, Чандмань, Эрдэнэбүрэн сумынхны өвөг дээдэс: Цувр.30.- УБ.: 2019.- 208х.- ISBN 978-99978-724-6-3.

63.5(5Мон)

М 816

2-94774 - 2-94776



Номд Дөрвөдийн Үнэн Зоригт хан аймгийн Өөлдийн Үйзэн засгийн хошуу, Чандмань уулын аймгийн Наранхайрхан уулын хошууны талаар болон аймаг, сумын шинэчилсэн зохион байгуулалт, Наранхайрхан уулын хошууны сумдын 1927 оны хүн амын тооллогыг оруулжээ.



12. Пүрэвдорж Г.

Засагт хан аймгийн Сэцэн сартуул хошуу / Хян. Г.Цэрэнханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 224х.- ISBN 978-9919-22-696-1.

63.5(5-M9)

П 915

3-18573 - 3-18575

Сартуулын Сэцэн засгийн хошууны үүх түүх, хошууны ноёдын угсаа, залгамжлал, хошууны түүхэн газар зүйн асуудал, засаг захиргаа, нийгэм эдийн засгийн байдал, хүн амын тоо, шилжилт суурьшил, овгийн бүрэлдэхүүн, хэл, угсаа, сэтгэл судлалын онцлог зэрэг олон сонирхолтой материалыг судалж эмхэтгэсэн байна.



13. Пүрэвжав Н.

Эрдэнийн шастиртай нутгийн энгүй домогтой дээдсийн хүү нь билээ би...: Дурсамж ном / Хян. Б.Пүрэвжав; Эмхэт. Л.Давааням, Л.Хэнтий ба бус.- УБ.: Адмон принт, 2019.- 838х.- ISBN 978-9919-22-068-6.

63.5(5-M9)

П 915

3-18521 - 3-18523


14. Сэцэн сартуул хошуу: Түүхэн баримт, судалгаа-II / Эмхэт. Г.Пүрэвсүрэн; Хян. Г.Цэрэнханд.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 240х.- (Ховд их сургууль).- ISBN 978-99978-870-1-6.

63.5(5-M9)

С 987

3-18570 - 3-18572

“Засагт хан аймгийн Сэцэн Сартуул хошуу”, “Сэцэн Сартуул хошуу” нэртэйгээр хоёр ном хэвлэлтээс гарч нээлтээ хийсэн байна. Энэхүү хоёр бүтээл мэндэлснээр Засагт хан аймгийн Сэцэн засгийн хошууны архивын баримт, түүхийн зохиол иж бүрэн гурван ботиор уншигч танаа хүрч байна. Хошууны түүх, бусад хошуудаас ялгагдах онцлог гээд олон арван асуултад хариулт өгсөн чамбай сайхан бүтээл болжээ.



15. Эрэгзэн Г. ба бус.

Гуа Довын хүннүгийн дурсгал / Г.Эрэгзэн, У Сэй Ён, Ким Жин Гён, П.Алдармөнх.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 337х.: Зур.- (ШУАТАХ., МҮМ., Солонгосын үндэсний музей).- ISBN 978-89-8164-191-7.

63.4(5Мон)

Г 661

3-18516 - 3-18520

Энэхүү ном нь Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүх, археологийн хүрээлэн, Монголын Үндэсний музей, Солонгосын Үндэсний музей хамтран хэрэгжүүлж буй “Мон-Сол” эрдэм шинжилгээний төслийн хүрээнд 2013-2016 онд Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Гуа довын Хүннүгийн дурсгалт газар хийсэн археологи, геофизикийн судалгааны үр дүнг нэгтгэсэн эрдэм шинжилгээний тайлан, хамтын бүтээл ажээ. Судалгаанд хамрагдсан дурсгалын байрлал, өндрийн хэмжээг GPS багаж ашиглан тогтоосон бөгөөд гар зурагт хойд зүгийг луужингийн хэмжилтээр тэмдэглэгээ хийж, газар усны нэр, хүний нэр зэргийг дуудлагыг баримтлан Монголоор буулгасан ба латин галигт олон улсад мөрдөж буй зарчмыг баримтлажээ.

Эдийн засаг. Эдийн засгийн шинжлэх ухаан



16. Наранхүү Л., Чинзориг Н.

Үйл ажиллагааны менежмент.- УБ.: Арвай бархан, 2020.- 526х.- ISBN 978-9919-22-872-9.

65.290-2

Н 294

3-18501 - 3-18505

“Үйл ажиллагааны менежмент” сурах бичгийн 3 дахь удаагийн хэвлэлд үйлвэрлэл, үйлчилгээг үр ашигтай зохион байгуулахад чиглэсэн менежментийн орчин үеийн тулгамдаж байгаа асуудлуудын талаар шийдвэр гаргахад хэрэглэгдэх энгийн аргуудаас гадна эдийн засаг математик загварчлалын аргууд, мэдээллийг компьютер дээр боловсруулах аргачлалуудыг нэмж оруулжээ. Мөн сэдэв бүрээр нэр томъёоны тайлбар өгч, мэдлэг шалгах асуултууд, ажиллах бодлого дасгалуудыг оруулсан байна.

17. Эрдэнэбат Д.


Хугацаан цуваа эконометрик.- УБ.: Адмон принт, 2017.- 316х.- ISBN 978-99978-1-498-2.

65в6

Э 739

3-18529 - 3-18532

Энэхүү ном нь хугацаан цуваан эконометрикийн үүдсэн загваруудыг танилцуулж байна. Эконометрикийн үндсэн ойлголтуудыг агуулсан бүлэгтэй. Мөн хугацааны цуваан эконометрикт өргөнөөр ашигладаг компьютерийн программуудыг танилцуулсан тусгай бүлгүүдтэй.



Улс төр. Улс төрийн шинжлэх ухаан
Төр эрх. Хууль цаазын шинжлэх ухаан



18. Батбаяр Б., Цэдэвсүрэн М.


Монгол улсын үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн түүх: Тойм лавлагаа, харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ.- УБ.: 2019.- 158х.- (Үндсэн хуульт ёс сан).- ISBN 978-99978-899-5-9.

67.400.1

Б 332

3-18576 - 3-18579

Уг ном нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тойм шинжилгээ, харьцуулсан судалгаа, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хийсэн дүн шинжилгээ гэсэн 2 хэсгээс бүрджээ.



19. Ширнэн Б.

Ардчилсан хувьсгал-1990: АИХ-ын сонгууль (дублёрууд): Б.9.- УБ.: Мөнхийн үсэг, 2019.- 407х.- ISBN 978-9919-9564-1-7.

66.63

Ш 678

3-18560 - 3-18562

1414 фото зураг, зурган файл бүхий, 2760 хуудастай “Ардчилсан хувьсгал 1990” 9 боть бүтээлийн төгсгөлийн IX боть анхны Ардчилсан сонгуулийн эхлэл, үйл явц, үр дүнгийн талаар архивын баримт эх сурвалжид түшиглэн өгүүлэхийн зэрэгцээ, АИХ-ын 430 тойрогт Ардчилсан хүчний нэрийн өмнөөс хоёр шатны сонгуульд нэр дэвшин өрсөлдөж, төвийн сонин хэвлэлүүдийн хуудаснаа албан ёсоор зарлагдсан 94, тэдгээрээс ялалт байгуулж депутатаар сонгогдсон 29-ийн талаар цухас дурьдахын цацуу, урьд өмнө хэн ч, хэзээ ч дурсаж байгаагүй, нийт олон үл мэдэх, харахан депутатаар сонгогдож чадаагүй ч тухайн үедээ ардчиллынхны нэр нүүр болон сонгуульд өрсөлдөж явсан түүхэн хүмүүс-66 дублёр-үүдийн дурсамж, дурдатгалыг оруулсан болно.

Боловсрол. Сурган хүмүүжүүлэх шинжлэх ухаан

Биеийн тамир. Спорт

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. Номын ажил

20. Баттогтох Д.

Монгол хэл, уран зохиол, үндэсний бичиг: Өгүүллэгийн дээжис.- УБ.: Удам соёл, 2019.- 224х.- ISBN 978-9919-21-912-7.

74.20

Б 341

3-18549 - 3-18552

Тус өгүүлэлд хүний хэл, сэтгэхүйн харилцан хамаарал, холбооны тухай болон өгүүлж буй бүхэн сэтгэхүйн үйл, үйлдлийн үр дүн байдгийг хэлний бодит жишээ баримтаар өгүүлжээ.



21. Дашжав Д.


Монгол маркийг судлахуй.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 560х.: Зур.- ISBN 978-99978-69-35-7.

76.19

Д 394

3-18536 - 3-1853

Номд маркуудыг он оноор нь үечлэн оруулжээ.



22. Дью Ж.

Ардчилал ба боловсрол, боловсролын философийн удиртгал / Ред. Б.Жадамба; Орч. А.Заяадэлгэр.- УБ.: Мөнхийн үсэг, 2018.- 400х.- ISBN 978-99978-2-690-9.

74

Д 808

3-18497 - 3-18500

Улс орон бүр өөр өөрийн зүрх сэтгэл, цусанд шингэсэн өвөг дээдсээс уламжилж ирсэн философийн үзэл баримтлалтай байдаг. Тэрхүү философи нь амьдралын хэв маяг, тухайн оронд тулгарч буй асуудал хэтийн зорилготой яв цав уялдан амьдрах арга ухаанаас нь урган гарсаар байгаа. Өөрийн философийн уламжлалд хөгжлийн бодлогод нийцтэй байгаа бусдын хөгжүүлсэн сайн сайхан санааг нийлүүлэн өргөтгөсөөр амьдралаасаа ухаарч ойлгосныг нэмсээр хүн хийгээд улс орон хөгждөг хэмээн бид ойлгодог...


23. Мэргэн буудлагын онол, арга зүй / Эмхэт. Г.Ууганбаяр; Ред. С.Энхжаргал, С.Баяр.- УБ.: Бэмби сан, 2019.- 330х.: Зур.- ISBN 978-9919-22-506-3.

75.723

М 971

3-18524 - 3-18528

Энэхүү ном нь зөвхөн хүчний байгууллагуудын мэргэн буудагчдад тусгайлан зориулагдаагүй бөгөөд манай улсад хурдацтай хөгжиж байгаа бенчрест, хэт холын зайн буудлага зэрэг өндөр нарийвчлалтай буудлага спортын тамирчид, түүнчлэн анчид, эхлэн сонирхогч буюу мэргэн буудагчдын залгамж халаа, баг бүрэлдэхүнийг бүрдүүлж байдаг бүх хүмүүст зориулагдсан байна.



24. Чимиддорж Н.

Дэлхийн өв Орхоны хөндийн соёлын дурсгалт газар дахь аялал жуулчлал.- УБ.: Арилдал, 2017.- 118х.: Зур.- ISBN 978-99978-0-424-2.

75.81

Ч-623

2-94732 - 2-94735

Орхоны хөндий нь байгаль, уур амьсгал, газар зүйн байршлын хувьд Төв Азийн нүүдэлчид өнө эртнээс бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдрах тааламжтай нөхцөл бүрдсэн өлгий нутаг нь болж байсан учир тэр үеийн нүүдэлчдийн түүх, соёлыг тод томруун илтгэн харуулсан, түүний хөдөлшгүй баримт, гэрч нотолгоо болсон булш хиргисүүр, ховор нандин хөшөө дурсгал, археологийн үнэ цэнэт олдворууд зэрэг нэн баялаг соёлын өвтэй. Нүүдэлчин монголчууд хил залгаа орших суурин соёл иргэншил бүхий улсуудтай худалдаа, арилжаа, цэрэг, оюун санааны салбарт харилцаа холбоо тогтоон тэдэнд нөлөөлж байв. Орхоны хөндийд эртний Уйгур улс, Их Монгол улсын нийслэл Хар балгас, Хархорум хотуудын тууриуд, бурханы шашны анхны төв Эрдэнэ Зуу, анхдугаар Богд

өндөр Гэгээн Г.Занабазарын нямба бясалгалын орон, Төвхөн, Шанхын Баруун хүрээ хийдүүд, Түрэгийн хаанБилгэ, түүний дууКультегинжанжиндзориулжбосгосонгэрэлтхөшөөзэрэгтмоохондурсгалуудбий.

Номын сангийн ажил. Номын сан судлал



25. Монгол улсын стандарт: Номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөх стандартын эмхэтгэл.- УБ.: СХГЗ., 2020.- 180х. 78.5ц М 692 3-18611 - 3-18614

Тус эмхэтгэлд 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулж шинээр батлагдсан стандартууд болон номын сан, мэдээллийн байгууллагад мөрдөгдөж буй стандартуудыг хамруулжээ.

26. Номын сангийн тухай яриа / Эмхэт. В.Түвшинтогтох, Т.Хайдав; Ред. Ч.Мөнх-Эрдэнэ, М.Отгонбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 216х.- ISBN 978-9919-22-537-7.

78.3 Н 728 2-94756 - 2-94760

Энэхүү номд орсон ярилцлагууд цаг хугацааны хувьд жаран жилийг хамарч байгаа бөгөөд энэ нь Монгол улсад номын сангийн салбарт мэргэжлийн ажилтан бэлдэж эхэлсэн үеэс өнөөг хүртэлх үйл явдлыг хамарч байгаагаараа онцлог юм.



Хэл шинжлэл


Аман зохиол. Аман зохиол судлал

Утга зохиол судлал



27. Батжаргал Д. Хүүхэд, уран зохиол, бид гурав / Ред. Д.Лхагвадорж.- УБ.: Бэмби сан, 2019.- 176х.: Зур.- ISBN 978-9919-22-628-2. 83.8 Б 335 2-94769 - 2-94773

Зохиогч энэхүү бүтээлдээ үзэл санаа, бодлоо Тэдэндээ би яаж харагдав, Тэднийгээ би яаж харав, Цэг, цэг, таслал гэсэн гурван бүлэгт багтаан илэрхийлжээ.



28. Цэцэн билигт дархад / Эмхэт. Д.Батжаргал.- УБ.: Бэмби сан, 2018.- 176х.- ISBN 978-99978-4-499-6.

82.3(5-M17)

Ц 978

2-94765 - 2-94768

Эмхэтгэгч цэцэн билигт дархад зоны зан заншил, хошин шог яриа, аялгуут сайхан дуу зэрэг биет бус өв соёлыг судлах, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор “Маанар” сонинд орсон зарим материалыг өөрийн бичсэн цөөн өгүүлэл, дархад шүлэгч, яруу найрагчдын зарим номын өмнөтгөл үгсийн хамт оруулжээ.

29. Чимиддорж Н.

Соёлын болон байгалийн өв, музей, аялал жуулчлалын англи-монгол толь / Хян. Ч.Батчимэг.- УБ.: Арилдал, 2019.- 206х.- ISBN 978-99978-66-44-8.

81.2Англ-4

Ч-623

2-94736 - 2-94740

Энэхүү толь нь түүх соёлын дурсгал, соёлын болон байгалийн өвийг түгээн дэлгэрүүлэх, хадгалах, хамгаалах, ашиглах, хойч үедээ өвлөн уламжлуулах, музей, жуулчлалын үйл ажиллагаа, менежемент, маркетингтэй холбоотой бичгийн болон ярианы хэлэнд өргөн хэрэглэгддэг мөн орчин үеийн технологийн дэвшил, даяаршлыг даган эдгээр өөр хоорондоо салшгүй холбоотой салбаруудын үйл ажиллагааны практик нэвтэрсэн 10000 орчим мэргэжлийн үг, нэр томъёонууд, хоршоо холбоо үгс, хэвшмэл болон орчин үеийн шинэ үг хэллэгийн хадмал орчуулгатай, дэлгэрэнгүй жишээнүүдтэй болно.



Уран зохиол (бүтээлүүд)



30. Баатар Т.

Хүн чоно: Бэсрэг роман / Зөвл. С.Цэвээнчимэд.- УБ.: Жиком пресс, [2019].- 212х.- ISBN 978-9919-21-370-1.

84(5Мон)-44

Б 111

2-94761 - 2-94764

...Шаазгайтын орой өвлийн цагт цас мөсөөр битүү хучигдаж бага гэсэн газартаа хүний бэлхүүсээр татах цастай тул хүн мал явахын аргагүй болж, үзэгдэх жигүүртэн шувуудаас өөр тэнд амьд амьтан байхгүй мэт боловч яг дотор нь яваад орвол янгир, аргалын сүрэг энд тэндгүй дайралдах агаад тэдгээр ан амьтдыг дагаад чоно ирвэс мэтийн махан хүнстэнгүүд ч сүргээрээ буюу ганц нэгээрээ амьдарч ирсэн ажээ. Эзэнгүй мэт харагдах Шаазгайтын ар талаас эх авсан Улиастай гол эгц босоо ханан хадаар хүрээлэгдсэн хавцал уруудан орж ирэх бөгөөд энэ бага шиг

голын дагууд нутгийн ганц нэг айл өвөл зунгүй байж, ялангуяа өвөлд хүн төрөлхтнөөс бараг тасарч их цас мөсийг хайлтал бөглүүдүү амьдарч ирсэн ажээ...



31. Ганхуяг Н.

Жүжгүүд / Ред. Х.Баясгалан, Т.Тэвтэнгэр.- УБ.: Бэмби сан, 2020.- 337х.- ISBN 978-9919-22-543-8.

84(5Мон)-6

Г 234

3-18563 - 3-18566

32. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Г.Аюурзана.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 480х.- ISBN 978 -9919-9512-3-8.

Б.1: Хэрмин Мэлвилл. Моби дик буюу цагаан халим.


84(0)-44

Д 893

2-94777 - 2-94780



Америкийн зохиолч Хэрман Мэлвиллын “Моби Дик буюу Цагаан Халим” хэмээх ном XIX зууны романтик утга зохиолын аугаа хийгээд гайхалтай бүтээлийн тоонд зүй ёсоор ордог. Энэхүү романы ихэнх үйл явдал тэр чигээрээ далай тэнгист өрнөж буйгаараа онцлог. Тэр тусмаа хоёр их гүрний дунд оршдог эх газрын манайх шиг орны уншигчдын хувьд далайн амьдрал тун чиг сонирхол татаж мэдэх юм. “Моби Дик”-ийн үйл явдал адармаатай, ямарч насныханд хүртээлтэй, ойлгоход хэцүү, нэн түвэгтэй асуудал үгүй тул уран зохиол шимтэн уншигчдад олон талын мэдрэмжийг төрүүлсэн онцгой гойд сонгодог бүтээл болох нь тодхон харагдана. Халим судлалын нэвтэрхий толь гэгддэг энэхүү романд хүн, байгалийн харьцаа, тэдгээрийн харилцан шүтэлцэл хийгээд эсрэг тэсрэг байр суурийг эрхэм зохиолч тод томруун харуулсан нь олзуурхууштай...



33. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Ж.Батбаатар.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 272х.- ISBN 978-9919-9512-2-8.

Б.2: Жэймс Жойс. Дублинчүүд.

84(0)-44

Д 893

2-94781 - 2-94784

Ирландын нэрт зохиолч Жэймс Жойсын “ертөнцийг” танин мэдэхийн эхлэл нь “Дублинчүүд” зохиол юм. Эл түүвэрт орсон өгүүллэгүүд нь 1904-1907 оны хооронд бичигдсэн бөгөөд реалист чиглэлийн бүтээлүүд зонхилно. Энэхүү түүврийн ач холбогдол нь Европын утга зохиол, тэр тусмаа өгүүллэгийн хөгжилд шинэ уур амьсгал, шинэ үе шатыг авчирч чадсанд оршино.

ДЭЛХИЙН
СОНГОДОГ
УТГА ЗОХИОЛ



34. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. О.Чинзориг.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 340х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.3: Жэймс Жойс. Зураачийн залуугийн хөрөг.

84(0)-44

Д 893

2-94785 - 2-94788

Жэймс Жойс “Зураачийн залуугийн хөрөг” хэмээх алдарт зохиолоо 1914 онд бичиж дуусгасан ба хоёр жилийн дараа буюу 1916 онд хэвлэн гаргажээ. Энэхүү роман нь зарим талаараа Жойсын намтартай ихээхэн холбоотой болох нь уншсан хэн бүхэнд тодорхой болно. Энэ роман бол зохиогчийн өөрийгөө дүгнэсэн, мөн өөрийгөө танин мэдэхэд чиглэсэн бүтээл

билээ. Зохиолын гол баатар Стивеней дүрийг бүтээхдээ Жойс орчин үеийн утга зохиолд “Ухамсрын урсгал” хэмээн нэрийдэж буй тэрхүү онцгой уран сайхны замыг сонгон туурвижээ. Уг роман нь тухайн үеийн Ирландын нийгмийн бугшмал амьдралыг олон талаас нь харуулснаас гадна дээрх зохиолуудын баатрууд “Үлисс” романд үргэлжлүүлэн амьдардагаараа онцлог юм.

35. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Г.Аюурзана.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 396х.- ISBN 978-9919-9212-3-8.

Б.4: Жэймс Жойс. Үлисс.


84(0)-44

Д 893

2-94789 - 2-94792

Уг роман оюунлаг бөгөөд зохиолч нь учир битүүлэг, ээдрээтэй бичлэгт дуртай хүн. Зохиолч “Үлисс”-ийг 1914 оны гуравдугаар сараас 1921 оны аравдугаар сар хүртэл 7 жилийн хугацаанд бичжээ. Гэхдээ тодорхой утгаар бол уг роман бүр аль эрт бичигдсэн юм. Үл тасалдах үргэлжлэлтэй байдаг нь Жойсын уран бүтээлийн хэв шинж мөн. Романд хүмүүсийн мэдрэмж, харилцааны тухай өгүүлдэг. Дэлхийн хэмжээний биш боловч баатруудынх нь хувьд чухал, тэдний ч, уншигчийн ч сэтгэлийг ихэд хөндсөн тийм үйл хөдлөл, үйл явдал энд гарна.

ДЭЛХИЙН
СОНГОДОГ
УТГА ЗОХИОЛ




36. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Г.Аюурзана.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 374х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.5: Жэймс Жойс. Үлисс.

84(0)-44

Д 893

2-94793 - 2-94796



Уг роман оюунлаг бөгөөд зохиолч нь учир битүүлэг, ээдрээтэй бичлэгт дуртай хүн. Зохиолч “Үлисс”-ийг 1914 оны гуравдугаар сараас 1921 оны аравдугаар сар хүртэл 7 жилийн хугацаанд бичжээ. Гэхдээ тодорхой утгаар бол уг роман бүр аль эрт бичигдсэн юм. Үл тасалдах үргэлжлэлтэй байдаг нь Жойсын уран бүтээлийн хэв шинж мөн. Романд хүмүүсийн мэдрэмж, харилцааны тухай өгүүлдэг. Дэлхийн хэмжээний биш боловч баатруудынх нь хувьд чухал,

тэдний ч, уншигчийн ч сэтгэлийг ихэд хөндсөн тийм үйл хөдлөл, үйл явдал энд гарна.



37. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Г.Аюурзана.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 208х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.6: Оскар Уайльд. Дориан Грэйнд хөрөг.

84(0)-44

Д 893

2-94797 - 2-94800




38. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Г.Аюурзана.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 224х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.7: Франц Кафка. Шүүх ажиллагаа.

Франц Кафка бол орчин үеийн герман хэлт зохиолчдын хамгийн том төлөөлөгч билээ. Алдарт Шүүх ажиллагаа роман дээрээ 1914 оны наймдугаар сарын дунд үеэс эхлэн ажиллаж эхэлжээ. Чингээд мөн оны аравдугаар сар гэхэд тус романы бараг долоон гол бүлэг бичигдэж дууссан байсан агаад долоо, найм, есдүгээр бүлгийг бичиж эхэлсэн байжээ. Энэ үеэр өөрийн бичсэн захидал болон тэмдэглэлийн дэвтэрт зохиол нь гацаанд орсон тухай өгүүлсэн байдаг. Гэвч арванхоёрдугаар сар гэхэд романаа дахин үргэлжлүүлж, эхлүүлж орхисон бүлгүүдээ дуусгасан ч 1915 оны нэгдүгээр сарын дундуур уг романыг бичих ажил тэр чигээрээ тасалдахад хүрсэн байна. Түүнийг насан эцэслэсний дараа устгачихаарай хэмээн захисан “Шүүх ажиллагаа” романыг судлаач Макс Брод Берлины “Шмиде” хэвлэлийн газарт эрхлэн хэвлүүлжээ. Энэхүү романы талаар маш олон талаас авч үзсэн тайлал, тайлбарууд байдаг бөгөөд одоо ч маргаантай хэвээр буй нь тус зохиолын цар хүрээг илтгэх мэт.

Зохиолын баатар Йозеф К.-гийн тун хачирхалтай шүүх ажиллагааны тухай бэлгэ тэмдэг бүхий түүхэн домгийг тоталитар эрин үеийн он цагийн бичээс лугаа уншихад нэн сонирхолтой байх агаад энэхүү зохиол нь ганцаардмал, өөрийгөө хамгаалах чадваргүй хүмүүнийг хүн чанаргүй, бүхнийг аалзны тор мэт хэрсэн тогтолцоотой тэмцэж буй тухай өгүүлдэг билээ. Ямар ч утга учиргүй гэнэтийн баривчилгаа, айдсыг сүйрүүлэгч инерци, эсэргүүцэх чадваргүй болтол нь саажуулагч байдал, танил талаа эрж хайж ар өврийн хаалга хайх явдал хэр их газар авсныг, дүр нь тодорхойгүй шүүхийн машин, хууль сахиулагчдын худалдагдсан байдал хийгээд тухайн үеийн хүнд суртлыг ямар ч хачиргүйгээр дүрслэн харуулжээ.



39. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. О.Чинзориг.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 424х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.8: Андрей Платонов. Чевенгүр.

84(0)-44

Д 893

2-94805 - 2-94808

XX зууны Оросын уран зохиолын томоохон төлөөлөгч А.Платоновын зохиол бүтээлийг анх 1940-өөд оноос эхлэн орчуулж эхэлсэн бөгөөд Р.Чандлер, Т.Лангерак, Й.Синаду, Э.Арнда, Р.Ланду нарын Англи, Польш, Голланд, Герман, Японы дуун хөрвүүлэгчдийг энд нэрлэж болох билээ.

Чевенгүр роман нь өнөөдрийн байдлаар дэлхийн арав гаруй хэл дээр хөрвүүлэгджээ.

Чевенгүр романы үйл явдлыг сайтар тунгаан уншвал “Хааны орд” Ханские Дворики хэмээх тосгонд социализм байгуулж буй тухай хэсэг бий. Гэтэл “хаан”, “орд” гэх дээрх монгол үгс нь орос хэлний зээлдсэн үгсийн тоонд хэдийн оржээ. Энэхүү роман нь нэг ёсондоо егөөдсөн хошин өнгө аястай бүтээл бөгөөд мөн түүний дотор аугаа их эмгэнэл, хий мөрөөдөл, шашны сүжиг зэргийг ч багтаасан байна.

40. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. О.Чинзориг.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 268х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.9: Хэрман Хэссэ. Талын чоно.

84(0)-44

Д 893

2-94809 - 2-94812



Энэхүү зохиол нь хүмүүний оюун санааны амьдралын тухай өгүүлсэн оюун ухааны шугамыг анхлан нээгч роман бөгөөд энэхүү зохиолгүйгээр XX зууны герман хэлтний утга зохиолыг төсөөлөхийн аргагүй юм. Уг зохиол нь олонталаар зохиолчийн туулж өнгөрүүлсэн амьдралтай холбоотой бичигджээ.

Гэхдээ Харри Галлер хэмээх романы баатрыг Х.Хэссэгийн ихэр хэмээн тооцвол алдас болно. Өөрийгөө “Талын чоно” хэмээн нэрийдэж буй Галлер болях чучраа олохоо байсан, харуусалдавтсан зураач, түүнийг хүрээлэн буй орчинтой үг хэлээ ололцохоос нэгэнт өнгөрсөн, бүхнээс залхсан ганцаардмал нэгэн ажээ.

Романы үйл явдал Галлерын амьдралын бараг гурван долоо хоногийг хамарна. Хэсэг хугацаанд “Талын чоно” нэгэн жижигхэн хотод амьдарч байгаад дараа нь тэндээс ор мөргүй арилахдаа өөрийнхөө “Тэмдэглэл”-ийг үлдээсэн нь тус романы ихэнх хэсгийг эзэлнэ. Тэрхүү “Тэмдэглэл” нь хорвоо дээр өөрийнхөө орон зайг олж чадахгүй байгаа, гагцхүү амиа егүүтгэх бодлоор амьдарч, амьдрал гэдэг түүний хувьд өдөр бүр зовлон мэт санагдах тийм л нэгэн билиг танхай авьяаслаг хүний дүр цухалзана.



41. Дэлхийн сонгодог утга зохиол / Орч. О.Чинбаяр; Хян. Г.Аюурзана, Ц.Түмэнбаяр.- УБ.: Соёмбо принтинг, 2019.- 398х.- ISBN 978-9919-9512-3-8.

Б.10: Саша Соколов. Тэнэгүүдийн сургууль.

84(0)-44

Д 893

2-94813 - 2-94816

Саша Соколов “Орос Сэллинжер” гэх нэр алдрыг хүртсэн авч Жером Дэвид Сэллинжерийг бодвол, хүмүүний ертөнцтэй харилцаа холбоогоо тэр чигтээ таслаагүй бөгөөд үе үе бага сага бүтээл хэвлүүлж энд тэнд ярилцлага өгсөөр ирэв. Нөгөөтэйгүүр Оросын орчин цагийн нэрт яруу найрагч М.Амелин түүнийг бичлэгийн арга барилын хувьд Сэллинжертэй бус Жэймс Жойстой харьцуулсан нь дээр хэмээн дүгнэсэн байдаг. Владимир Набоковын хувьд түүний бичсэн “Тэнэгүүдийн сургууль”, “Тун чиг сэтгэл татам эмгэнэлтэй агаад ихэд сэтгэл хөдөлгөсөн ном доо” хэмээн тодорхойлжээ.

42. Лондон Ж.


Адамаас өмнө / Орч. Ж.Отгонбаяр.- УБ.: Жиком пресс, 2019.- 200х.- ISBN 978-9919-22-222-2.

Цувр.6: Софило.

84(7АНУ)-44

Л 752

2-94718 - 2-94722



Хүн судлал, хүний философи, утга соёл, угсаатан судлал, заншилзүйг чухалчилдаг, Философи, хүмүүнлэгийн ухааны эрт эдүгээгийн сонгодог бүтээл, философичдын үзэл бодол, үйл хэргээс дээжлэн хүргэхийг зорьдог Софило цувралын зургаадугаар номоор Америкийн реалист зохиолч Жек Лондонгийн реалист биш шинжлэх ухааны утга зохиол болох “Адамаас өмнө” ном орос хэлнээс орчуулагдан уншигч танд хүрч байна.



43. Мөнхтуяа Б.

Шидэт хуудас / Зур. С.Шүрэнцэцэг.- УБ.: Адмон принт, 2019.- 65х.: Зур.- ISBN 978-9919-22-911-5.

84(5Мон)-44

М 816

3-18603 - 3-18607

Тодоо, Гэгээ бид гурав даалгавраа амжилттай бэлдэж, жүжгээ ч маш сайн тоглов. Багш маань гурван сурагчаа эвтэй найртай болсныг хараад, ээж аавууд минь бидний тоглосон жүжгийг үзээд бид гурваар үнэхээр их бахархсан нь даамжиггүй...

44. Туяа Б.

Тэнгэрийн тамга / Хян. Ч.Бирадамба.- УБ.: Соёмбо принтинг, 2019.-
343х.: Зур.- ISBN 978-9919-22-778-4.

84(5Мон)-44

Т 727

3-18546 - 3-18548



45. Чинзориг Н.

Өндөг бүхэн шувуу болдоггүй.- УБ.: 2019.- 212х.- ISBN 978-9919-
22-196-6.

84(5Мон)-4

Ч-63

2-94712 - 2-94717


46. Ядмаа З.

Баруун тархины хоржоонтой хошигнол: Шог хошин шүлэг найраглал,
нөхөрсөг шог, найзархаг наргиа, элэгсэг элэглэл, ёсорхог ёжлол / Зур.
Ц.Жандал.- УБ.: Жиком пресс, 2019.- 286х.- ISBN 978-9919-22-642-8.

84(5Мон)-7

Я 368

2-94728 - 2-94731



Олон зохиогч нөхдийн маань оюунаас оргилж, ухаанаас ундарсан
даажигнасан, наргисан, ёжилсон,ажилсан, шоглосон, тоглосон, элэглэсэн,
шүлэглэсэн баруун тархины хоржоонтой хошигнолоос дээжлэн барьжээ.

Урлаг. Гүн ухаан



47. Бидний эх, гавьяат жүжигчин Мятавын Бадамгарав / Эмхэт.
П.Батчимэг; Ред. Г.Жавзанжав.- УБ.: Наран зон принт, 2019.- 304х.: Зур.-
ISBN 978-9919-22-503-2.

85.374

Б 464

3-18567 - 3-18569

Гавьяат жүжигчин Мятавын Бадамгаравын мэндэлсний 100
жилийн ойд зориулан гаргажээ.

48. Боас Ф.

Балар эртний хүний оюун ухаан / Орч. Ж.Отгонбаяр.- УБ.: Жиком пресс, 2019.- 304х.- ISBN 978-9919-22-138-6.


Цувр.5: Софило.

87

Б 521

2-94723 - 2-94727

Хүн судлал, хүний философи, утга соёл, угсаатан судлал, заншилзүйг чухалчилдаг Софило цуврал 2017 оноос эхлэн хэвлэгдэж байгаа ба энэхүү цувралын 5 дахь номоор Франц Боасын энэхүү бүтээл хэвлэгдсэн ба Хүний дээд доод төрөлхтөн болох жинхэнэ шалтгаан нь арьсны өнгө мөн үү гэсэн асуултанд шинжлэх ухааны үндэслэлтэй хариулт өгдөг энэхүү номыг орос хэлнээс хөрвүүлэгдэн уншигч танд хүрч байна.



49. Галиндэв Б.

Лев Толстойн ертөнц ба хүний асуудал / Хян. Н.Жамбалжав.- УБ.: Сэлэнгэпресс, 2019.- 340х.- ISBN 978-9919-21-643-6.

87.22

Г 199

3-18539 - 3-18542

Сэтгэл судлал

50. Нарантуяа Л., Халиун Ц.

Гэр бүлийн амьдрал: Цувр.1 / Хян. П.Увш.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 176х.: Зур.- ISBN 978-99962-2-322-8.

88.5

Н 294

2-94817 - 2-94821

Аливаа үндэстэн ястан ард түмнийг ёс заншилаас нь салангид авч үзэх аргагүй юм. Хүний нийгэмд монголчуудын өвөг болох Хүннүгийн үеэс оруулсан соёлын өв санг бид хэлж баршгүй. Монгол гэр бүл мянга мянган жилийн сорилт шахалтыг давж, өөрийн онцлогт тохирсон ёс заншил, хүмүүжлийн гүн ухааныг бий болгосон. Манай ард түмний сурган хүмүүжүүлэх арга нь хүнийг эхийн хэвлийд үүсэхээс эхлээд хорвоогийн мөнх бусыг үзүүлэх хүртэлх бүх үеийг хамардгаараа онцлогтой. Гэр бүлийн эхнэр, нөхрийн зан төлөв, ёс заншил нь өрх гэрийн хорол тооныг түших хос зандан багана болж гэр бүлийн төдийгүй нийгмийн төлөвшилт болон ирээдүй хойч үеийнхний итгэл найдварыг буй болгох хувь заяаг тодорхойлж байдаг. Уг номонд гэрлэлтийн утга учир, гэр бүлийн амьдрал, хосуудын бэлгийн амьдрал, аз жаргалтай амьдрах арга зам, гэр бүл салалт, итгэл үнэмшил, дурлал ба шохоорхол, ардын уламжлалт ёс заншил, хуримын ёсны талаар өгүүлнэ.




51. Нарантуяа Л., Халиун Ц.

Гэр бүлийн амьдралын нууц: Цувр.2 / Хян. П.Увш.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 276х.: Зур.- ISBN 978-99962-2-321-1.

88.5

Н 294

2-94822 - 2-94826



Зохиогч хосуудын харилцан сэтгэл авах, сэтгэл өгөх, сэтгэлээ ойлголцох, сэтгэлээ онгойлгох, сэтгэлд итгэх, сэтгэлийг тогтоох, сэтгэл хөгжүүлэхэд зориулсан “Гэр бүлийн амьдрал-2” гарын авлага номоо толилуулж байна. Сэтгэл зүйч, эмч, цагдаа, хууль хяналтын байгууллагын ажилтнууд, ЕБС-ийн багш, аж ахуйн нэгжийн хүний нөөцийн ажилтан, Хорооны нийгмийн ажилтан, дасгалжуулагч, нийгмийн чиглэлээр сурч буй оюутнууд зэрэг хүнтэй харилцаж ажил үйлчилгээ явуулдаг хэн боловч энэхүү мэдээллийг авч, ажил амьдралдаа туршиж үзээд өөрийн мэдлэг болгон бизээ.



52. Нарантуяа Л., Халиун Ц.

Гэр бүлийн харилцааны алтан судар: Цувр. 3 / Хян. П.Увш.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 212х.: Зур.- ISBN 978-99962-2-320-4.

88.5

Н 294

2-94827 - 2-94831

Хуульч, гэр бүл судлаач Л.Нарантуяа энэхүү цуврал бүтээлдээ өдөр тутмын гэр бүлийн дотоод амьдралын хайрын харилцаанд бодитойгоор туслах зорилгоор хосууд амьдралдаа тусгах, дадлагажуулах, харилцах чадвартай болоход зориулсан зөвөлгөөнүүдийг илүүтэйгээр агуулсан бөгөөд гэр бүл болохын учир, эхнэр нөхрийн хариуцлага, гэр бүлийн харилцаанд юуг анхаарах, аз жаргалтай гэр бүлийн алтан дүрэм, эвтэй амьдрах ухаан зэрэг сэдвүүдийг хөндсөн байна.

53. Нарантуяа Л., Халиун Ц.

Хүүхдээ хүмүүжүүлэх болор судар: Цувр.4 / Хян. П.Увш.- УБ.: Соёмбо принтинг, 2018.- 146х.: Зур.- ISBN 978-99962-2-318-1.

88.8

Н 294

2-94832 - 2-94836



Энэхүү ном нь өнөөгийн монголын гэр бүлд өдөр тутмын гэр бүлийн харилцаанд хүүхдээр хүн хийх ариун үйлсэд бодитойгоор туслах зорилгоор, шинэ шинэ өөр, өөр соёлыг өрх гэр бүрт үүсгэхэд санаа өгөх зөвлөмжүүдийг харамгүй хайрласан байна. Уг номд хүүхдийн хүмүүжил, түүний арга хэлбэрүүд, хүүхдийн авъяас сонирхол, боловсролд хэрхэн анхаарах, хүүхдийг яаж дуулгавартай болгох, хөвгүүд болон охидын хүмүүжлийн онцлог, шийтгэл хүүхдэд тохирох эсэх, урамшуулал, эцэг эхийн зан төлөв, биеэ авч явах байдал хүүхдэд хэрхэн нөлөөлөх, хүүхдийн бие даасан байдлыг хадгалах, тэднийг хүмүүжүүлэх гэрийн сургалтын тухай өгүүлжээ.

54. Нарантуяа Л., Халиун Ц.

Шинэ зууны хүүхэд хөгжил: Цувр. 5 / Хян. П.Увш.- УБ.: Соёмбо
принтинг, 2018.- 160х.: Зур.- ISBN 978-99962-2-318-1.

88.8

Н 294

2-94837 - 2-94841



“Хүний хөгжлийн тайлагдашгүй нууцыг өөртөө шингээсэн хүүхэд гэдэг аугаа ертөнцийн тухай ээж хүний хувьд мэддэг зүйлээ бусадтай хуваалцах завшаан олдлоо” хэмээн зохиогч өгүүлжээ. Хүнтөрөлхтөн мөнхийн амьдралыг зөвхөн үр хүүхэд төрүүлж өсгөснөөр эдэлдэг. Хорвоогийн гурван их буяны нэг нь хүүхэд төрүүлж өсгөх, хоёр дахь нь ном бүтээх, гурав дахь нь байгаль дэлхийгээ хайрлаж мод тарих явдал юм. Эцэг эх өөрийн мэдэхгүй зүйлээр хүүхдээ хүмүүжүүлж чадахгүй. Иймээс чаддаг байж ирээдүй хойч үедээ оюуны хөрөнгө оруулалт хийхийн учир энэхүү номоо бүтээсэн байна. Уншсан бүхнээ бүтээлчээр амьдралдаа хийж, туршаад өөрсдийн гэр бүлийн мэдлэг болгоорой.



55. Нарантуяа Л., Халиун Ц.

Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө: Цувр.6 / Хян. П.Увш.- УБ.: Соёмбо
принтинг, 2016.- 176х.- ISBN 978-99962-2-323-5.

88.5

Н 294

2-94842 - 2-94846

Гэр бүлийн сэтгэл зүйн зөвлөгөө нь сэтгэл судлалын хэрэглээний салбарын дотор чухал байр суурь эзэлдэг биеэ даасан шинжлэх ухаан юм. Энэхүү шинжлэх ухааныг судалснаар гэр бүлд тохиолдож байгаа бэрхшээлтэй олон асуудлуудыг шийдвэрлэх онол арга зүйн мэдлэг, арга барил ур чадвараа сайжруулах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх таатай боломжууд нээгдэнэ. Тэрээр гэр бүлд тохиолддог нийтлэг асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглаж байгаа сэтгэл зүйн зөвлөгөөний онол-арга зүйн асуудлуудыг энэ номонд онцлон авч үзжээ. Ялангуяа эцэг эхчүүд өөрсдөө энэ номд оруулсан практик зөвлөмж, арга техникүүдийг гэр бүлийн асуудлаа шийдвэрлэхэд хэрэглэн турших боломжтой юм. Мөн өдөр тутмын амьдралын тохиолдол, жишээнүүд, асуулт даалгавар, зөвлөмжүүдийг оруулж өгсөнөөр “Сэтгэл зүйн зөвлөгөө, алба” хичээлээр олж авсан онолын мэдлэгээ гүнзгийрүүлэн бататгахад ач холбогдолтой болно.

56. Нарантуяа Л., Гүнбилэг Ц.

Нарны охины нандин судар: Цувр.7 / Зөвл. Т.Аачгар.- УБ.: Соёмбо
принтинг, 2017.- 464х.- ISBN 999780805-3.

88.5

Н 294

2-94847 - 2-94851



Ерөнхий агуулгатай лавлагааны гарын авлага



57. МУИС-ийн номын сангийн номзүйн бүртгэл: Магистр, докторын судалгааны бүтээл: 1970-2018: Б.2 / Эмхэт. С.Найгалмаа, У.Гэрэлтуяа ба бус.; Ерөн ред. О.Нарантуяа; Ред. М.Кунай, Ж.Оюунчимэг.- УБ.: Бэмби сан, 2019.- 1039х.-(МУИС).- ISBN 978-9919-504-00-7.
91
М 692 3-18553 - 3-18556

Энэхүү бүтээлд МУИС-ийн номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй магистрын 6447, докторын 661 судалгааны бүтээлийг /1970-2018 он/ хамруулсан болно. Уг номзүйн бүртгэл нь эрдэмтэн багш, судлаач, докторант, магистрант болон нийт уншигчдын судалгаа, эрдэм шинжилгээний ажилд үнэ цэнэтэй гарын авлага болох юм.

58. Соёмбо нэвтэрхий толь: Эм, цэцэрлэгийн ургамал / Ерөн. ред. Ч.Содномцэрэн, Ц.Цэндээхүү.- УБ.: Соёмбо принтинг, 2020.- 488х.: Зур.- ISBN 978-99978-6-381-2.

92
С 527 3-18608 - 3-18610



Энэхүү нэвтэрхий толь нь ботаник, ургамлын аж ахуй, генийн сан, интродукцийн шинжлэх ухааны талаарх хамгийн торгон, хамгийн өргөн, түгээмэл танин мэдэхүйн ойлголт өгч мэдээллийг мэдлэг, мэдлэгийг баялаг болгон ашиглахад чиглэгдсэн анхдагч эх материал болно.

Гарчиг

Байгалийн шинжлэх ухаан.....	1
Техник. Техникийн шинжлэх ухаан.....	2
Эрүүлийг хамгаалах. Анагаахын шинжлэх ухаан.....	3
Түүх. Түүхийн шинжлэх ухаан.....	3
Улс. Улс төрийн шинжлэх ухаан	
Төр эрх. Хууль цаазын шинжлэх ухаан.....	6
Боловсрол. Сурган хүмүүжүүлэх шинжлэх ухаан Биеийн тамир. Спорт	
Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл. Номын ажил.....	7
Номын сангийн ажил. Номын сан судлал.....	9
Хэл бичгийн шинжлэх ухаан. Хэл шинжлэл	
Аман зохиол. Аман зохиол судлал	
Утга зохиол судлал.....	9
Уран зохиол (бүтээлүүд).....	10
Урлаг. Урлаг судлал.....	16
Сэтгэл судлал.....	17
Ерөнхий агуулгатай лавлагааны гарын авлага.....	20

Бэлтгэсэн: Номзүйч Б.Цогжаргал

